



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БЭРХ ХОТЫН ЗАХИРАГЧИЙН
ЗАХИРАМЖ**

2026 оны 04 сарын 23 өдөр

Дугаар 1125

Бэрх хот

**Хөрөнгө
зарцуулах тухай**

Монгол Улсын “Хот тосгоны эрх зүйн байдлын тухай” хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалын хавсралт “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дах заалт, Захирагчийн Зөвлөлийн 2026 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн №06 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус хотод Аймгийн Засаг даргын нэрэмжит “Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг”-ийн бэлтгэл, бэлэн байдлыг хангах зорилгоор 685.000 төгрөгийг зарцуулсугай.

2.Шаардагдах 685.000 (Зургаан зуун наян таван мянган) төгрөгийг Захирагчийн эрсдэлийн сангаас холбогдох хууль, дүрэм, журмын дагуу гаргахыг Нягтлан бодогч (Г.Осгонжаргал)-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү албаны дарга (П.Янжмаа)-д даалгасугай.

ЗАХИРАГЧ



Ч.ЭНХЖАВХЛАН

232 601 050